



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН  
ХОРШООДЫН  
2020 ОНЫ НЭГДҮГЭЭР  
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2020 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА


Улаанбаатар хот

### НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 254 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.9 хувь буюу 28-аар буурсан үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотод 160 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 хувь буюу 18-аар буурсан үзүүлэлттэй байгаа бол орон нутагт 94 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.6 хувь буюу 10-аар буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-дын тооны өсөлтийг өмнөх онуудтай харьцуулж харуулбал:

График 1



Тайлант улиралд Хорооны хуралдаанаар шинээр 2 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 12 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 9 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 6 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлуудыг шийдвэрлэсэн бөгөөд хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Он	Шинээр олгосон	Хүчингүй болгосон	Түдгэлзүүлсэн	Сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	ХЗХ-дын тоо
2016.I улирал	21	3	1	-	11	271
2017.I улирал	2	-	3	-	16	282
2018.I улирал	9	11	11	2	39	288
2019.I улирал	4	1	1	-	6	282
2020.I улирал	2	9	6	-	12	254

Тайлант улиралд 9 ХЗХ-ны сонгуульт гишүүд, гүйцэтгэх албаны өөрчлөлт, 2 ХЗХ-ны оршин байх хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэсэн.

ХЗХ-дыг үйл ажиллагааны төрлөөр нь харуулбал:

Хүснэгт 2

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ХЗХ-дын тоо	
		2019.1	2020.1
1	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	282	254
2	Төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	113	102
3	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	3	3
4	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	3	4
5	Салбарын зөвшөөрөлтэй	7 /салбар-27/	7 /салбар-61/

Нийт 102 ХЗХ төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байгаагийн 4 нь орон нутагт, 98 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг хоршоод байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэгт ХЗХ-д үйл ажиллагаа эрхэлж байгаагаас Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 1



Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд Сэлэнгэ аймгаас бусад аймагт тархалттай байна. Орхон, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай аймгуудад ХЗХ ихээр төвлөрсөн байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2



ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 74,701-д хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.7 хувь буюу 8,405-аар өссөн үзүүлэлт юм. Нийт гишүүдийн 53.9 хувь буюу 40,298 нь эмэгтэй гишүүд байна.

Нийт гишүүдийн 66.2 хувь буюу 49,450 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүд, 33.8 хувь буюу 25,251 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүд байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын нийт гишүүдийн 18.4 хувь буюу 9,093 нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 94 ХЗХ-ны гишүүд байна.

График 2



Гишүүнчлэлийн хувьд нийт 254 ХЗХ-ны 127 буюу 50.0 хувь 20-100 гишүүнтэй, 101 буюу 39.8 хувь 101-500 гишүүнтэй, 18 буюу 7.1 хувь 501-1,000 гишүүнтэй, 8 буюу 3.1 хувь 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

График 3



Гишүүнчлэлийн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

№	Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх %
1	20-100 гишүүнтэй	127	7,570	10.1%
2	101-500 гишүүнтэй	101	19,676	26.3%
3	501-1,000 гишүүнтэй	18	11,000	14.7%
4	1,001-ээс дээш гишүүнтэй	8	36,455	48.8%
	Нийт	254	74,701	100%

1,001-ээс дээш гишүүнтэй 8 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 48.8 хувийг эзэлж байна.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХЗХ-ны салбарын 2020 оны 1 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд тусгай зөвшөөрөлтэй 254 ХЗХ-ноос 26 ХЗХ өмнөх улирлын тайлангаар, 4 ХЗХ эхлэлтийн тайлангаар хамрагдлаа.

### 2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 4

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	НИЙТ 254 ХЗХ-НЫ ГИШҮҮД		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот дахь 160 ХЗХ		Орон нутаг дахь 94 ХЗХ	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Нийт гишүүдийн тоо</b>	<b>74,701</b>	<b>100%</b>	<b>49,450</b>	<b>100%</b>	<b>25,251</b>	<b>100%</b>
Үүнээс: эмэгтэй	40,298	53.9%	28,082	56.8%	12,216	48.4%
Үүнээс: гишүүн хуулийн этгээд	140	0.2%	93	0.2%	47	0.2%
<b>Гишүүдийн насжилт</b>	<b>74,561</b>	<b>100%</b>	<b>49,357</b>	<b>100%</b>	<b>25,204</b>	<b>100%</b>
18-35 насны	21,938	29.4%	15,257	30.9%	6,681	26.5%
36-45 насны	25,313	33.9%	17,791	36.0%	7,522	29.8%
46-55 насны	16,095	21.6%	9,611	19.5%	6,484	25.7%
55-аас дээш	11,215	15.0%	6,698	13.6%	4,517	17.9%
<b>Гишүүдийн боловсрол</b>	<b>74,561</b>	<b>100%</b>	<b>49,357</b>	<b>100%</b>	<b>25,204</b>	<b>100%</b>
Дээд	34,177	45.8%	26,139	53.0%	8,038	31.9%
Тусгай дунд	9,392	12.6%	5,595	11.3%	3,797	15.1%
Бүрэн дунд	23,157	31.1%	15,918	32.3%	7,239	28.7%
Дунд	6,121	8.2%	1,470	3.0%	4,651	18.5%
Бага	1,714	2.3%	235	0.5%	1,479	5.9%
<b>Нийт ажилтнуудын тоо</b>	<b>810</b>	<b>100%</b>	<b>547</b>	<b>100%</b>	<b>263</b>	<b>100%</b>
Эмэгтэй ажилтнуудын тоо	592	73.1%	412	75.3%	180	68.4%
<b>Санхүүгийн програмтай</b>	<b>83</b>	<b>32.7%</b>	<b>39</b>	<b>15.4%</b>	<b>44</b>	<b>17.3%</b>

ХЗХ-ны гишүүдийн насжилт болон боловсролын байдлыг графикаар харуулбал:

График 4

Гишүүдийн насжилт





График 5

Гишүүдийн боловсрол



ХЗХ-дын нийт гишүүдийн дунд 18-45 насныхан зонхилж байгаа бол нийт гишүүдийн 46.0 хувь дээд боловсрол эзэмшсэн байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны I улирал	2020 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	282	254	-28	-9.9%
2	Гишүүдийн тоо	66,296	74,701	8,405	12.7%
3	<b>Нийт хөрөнгө</b>	<b>211,670,034.3</b>	<b>229,534,745.9</b>	<b>17,864,711.6</b>	<b>8.4%</b>
4	Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.7%	-	-
5	<b>Нийт зээл</b>	<b>157,555,631.6</b>	<b>172,940,234.8</b>	<b>15,384,603.2</b>	<b>9.8%</b>
6	Банкны салбарт эзлэх хувь	0.9%	1.0%	-	-
7	<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>6,047,575.4</b>	<b>7,410,270.0</b>	<b>1,362,694.6</b>	<b>22.5%</b>
8	Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.8%	4.3%	0.5%	12.8%
9	Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.4%	-	-
10	<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>150,978,793.2</b>	<b>159,015,824.5</b>	<b>8,037,031.3</b>	<b>5.3%</b>
11	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.2%	-	-
12	<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>15,875,784.0</b>	<b>18,414,215.3</b>	<b>2,538,431.3</b>	<b>16.0%</b>
13	<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>16,191,725.9</b>	<b>24,646,588.8</b>	<b>8,454,862.9</b>	<b>52.2%</b>
14	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	7,775,408.3	10,680,697.9	2,905,289.6	37.4%
15	<b>Нийт орлого</b>	<b>12,622,721.0</b>	<b>14,033,161.8</b>	<b>1,410,440.8</b>	<b>11.2%</b>
16	<b>Нийт зарлага</b>	<b>12,169,026.6</b>	<b>11,838,456.6</b>	<b>-330,570.0</b>	<b>-2.7%</b>
17	<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>453,694.4</b>	<b>2,194,705.1</b>	<b>1,741,010.7</b>	<b>383.7%</b>

ХЗХ-ны салбарын нийт хөрөнгийн банкны салбарт эзлэх хувь 0.6 хувь байна. Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.4 хувь буюу 17,864,711.6 мянган төгрөгөөр, нийт зээл 9.8 хувь буюу 15,384,603.2 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 5.3 хувь буюу 8,037,031.3 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Салбарын нийт чанаргүй зээлийн үлдэгдэл нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өссөн бол нийт орлого 11.2 хувь буюу 1,410,440.8 мянган төгрөгөөр өсөж, нийт зарлага 2.7 хувь буюу 330,570.0 мянган төгрөгөөр буурснаар нийт цэвэр орлого 383.7 хувь буюу 1,741,010.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

## 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 6 /мянган төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны I улирал	2020 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	178	160	-18	-10.1%
2	Гишүүдийн тоо	41,434	49,450	8,016	19.3%
3	ХЗХ-ны нийт гишүүдийн тоонд эзлэх хувь	62.5%	66.2%	3.7%	5.9%
4	<b>Нийт хөрөнгө</b>	<b>185,067,608.7</b>	<b>198,024,810.3</b>	<b>12,957,201.6</b>	<b>7.0%</b>
5	ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	87.4%	86.3%	-1.1%	-1.3%
6	<b>Нийт зээл</b>	<b>136,040,943.3</b>	<b>147,504,485.0</b>	<b>11,463,541.7</b>	<b>8.4%</b>
7	ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	86.3%	85.3%	-1.0%	-1.2%
8	<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>5,629,116.5</b>	<b>6,827,946.8</b>	<b>1,198,830.3</b>	<b>21.3%</b>
9	ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	93.1%	92.1%	-1.0%	-1.0%
10	Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.1%	4.6%	0.5%	12.9%
11	<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>134,417,960.3</b>	<b>139,574,195.9</b>	<b>5,156,235.6</b>	<b>3.8%</b>
12	ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	89.0%	87.8%	-1.2%	-1.4%
13	<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>10,985,624.3</b>	<b>13,032,020.0</b>	<b>2,046,395.7</b>	<b>18.6%</b>
14	ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	69.2%	70.8%	1.6%	2.3%
15	<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>12,811,514.2</b>	<b>19,960,768.5</b>	<b>7,149,254.3</b>	<b>55.8%</b>
16	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	79.1%	81.0%	1.9%	2.4%
17	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	6,914,762.6	10,549,541.1	3,634,778.5	52.6%
18	<b>Нийт орлого</b>	<b>10,426,757.8</b>	<b>11,698,152.4</b>	<b>1,271,394.6</b>	<b>12.2%</b>
19	<b>Нийт зарлага</b>	<b>10,337,877.5</b>	<b>10,011,090.4</b>	<b>-326,787.1</b>	<b>-3.2%</b>
20	<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>88,880.3</b>	<b>1,687,062.0</b>	<b>1,598,181.7</b>	<b>1,798.1%</b>

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 160 ХЗХ-ны нийт хөрөнгө 198,024,810.3 мянган төгрөг нь салбарын 86.3 хувь, нийт зээл 147,504,485.0 мянган төгрөг нь салбарын 85.3 хувь, нийт хадгаламж 139,574,195.9 мянган төгрөг нь салбарын 87.8 хувийг тус тус эзэлж байна. ХЗХ-ны салбарын нийт чанаргүй зээлийн 92.1 хувийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээл эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 12.2 хувь буюу 1,271,394.6 мянган төгрөгөөр өссөн бол нийт зарлага 3.2 хувь буюу 326,787.1 мянган төгрөгөөр буурч, цэвэр орлого 1,798.1 хувь буюу 1,598,181.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 7 /мянган төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны I улирал	2020 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	104	94	-10	-9.6%
2	Гишүүдийн тоо	24,862	25,251	389	1.6%
3	ХЗХ-ны нийт гишүүдийн тоонд эзлэх хувь	37.5%	33.8%	-3.7%	-9.9%
4	<b>Нийт хөрөнгө</b>	<b>26,602,425.6</b>	<b>31,509,935.5</b>	<b>4,907,509.9</b>	<b>18.4%</b>
5	ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	12.6%	13.7%	1.1%	9.0%
6	<b>Нийт зээл</b>	<b>21,514,688.2</b>	<b>25,435,749.8</b>	<b>3,921,061.6</b>	<b>18.2%</b>
7	ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	13.7%	14.7%	1.0%	7.4%
8	<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>418,458.9</b>	<b>582,323.2</b>	<b>163,864.3</b>	<b>39.2%</b>
9	ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	6.9%	7.9%	1.0%	13.9%
10	Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.3%	0.3%	0.1%	26.8%
11	<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>16,560,832.9</b>	<b>19,441,628.6</b>	<b>2,880,795.7</b>	<b>17.4%</b>
12	ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	11.0%	12.2%	1.2%	11.1%
13	<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>4,890,159.7</b>	<b>5,382,195.3</b>	<b>492,035.6</b>	<b>10.1%</b>
14	ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	30.8%	29.2%	-1.6%	-5.1%
15	<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>3,380,211.8</b>	<b>4,685,820.3</b>	<b>1,305,608.5</b>	<b>38.6%</b>
16	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	20.9%	19.0%	-1.9%	-9.0%
17	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	122,288.8	131,156.8	8,868.0	7.3%

18	<b>Нийт орлого</b>	<b>2,195,963.2</b>	<b>2,335,009.4</b>	<b>139,046.2</b>	<b>6.3%</b>
19	<b>Нийт зарлага</b>	<b>1,831,149.1</b>	<b>1,827,366.2</b>	<b>-3,782.9</b>	<b>-0.2%</b>
20	<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>364,814.0</b>	<b>507,643.2</b>	<b>142,829.2</b>	<b>39.2%</b>

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 94 ХЗХ-ны нийт хөрөнгө 31,509,935.5 мянган төгрөг нь салбарын 13.7 хувь, нийт зээл 25,435,749.8 мянган төгрөг нь салбарын 14.7 хувь, нийт хадгаламж 19,441,628.6 мянган төгрөг нь салбарын 12.2 хувийг тус тус эзэлж байна. ХЗХ-ны салбарын нийт чанаргүй зээлийн 7.9 хувийг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээл эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 6.3 хувь буюу 139,046.2 мянган төгрөгөөр өссөн бол нийт зарлага 0.2 хувь буюу 3,782.9 мянган төгрөгөөр буурч, цэвэр орлого 39.2 хувь буюу 142,829.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

### 2.2.3 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан, уг хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 8 /мянган төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны I улирал	2020 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	104	94	-10	-9.6%
2	Гишүүдийн тоо	9,674	9,093	-581	-6.0%
3	ХЗХ-ны нийт гишүүдийн тоонд эзлэх хувь	14.6%	12.2%	-2.4%	-16.6%
4	<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,585,772.5</b>	<b>9,675,522.5</b>	<b>-1,910,250.0</b>	<b>-16.5%</b>
5	ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	5.5%	4.2%	-1.3%	-23.4%
6	<b>Нийт зээл</b>	<b>9,779,273.6</b>	<b>7,926,441.3</b>	<b>-1,852,832.3</b>	<b>-18.9%</b>
7	ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	6.2%	4.6%	-1.6%	-26.1%
8	<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>238,253.9</b>	<b>234,964.0</b>	<b>-3,289.9</b>	<b>-1.4%</b>
9	ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	3.9%	3.2%	-0.7%	-18.7%
10	Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.2%	0.1%	0.0%	-10.2%
11	<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>2,203,478.6</b>	<b>2,231,452.5</b>	<b>27,973.9</b>	<b>1.3%</b>
12	ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	1.5%	1.4%	-0.1%	-6.4%
13	<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>977,114.0</b>	<b>824,362.7</b>	<b>-152,751.3</b>	<b>-15.6%</b>
14	ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	6.2%	4.5%	-1.7%	-27.8%
15	<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>429,946.1</b>	<b>353,741.7</b>	<b>-76,204.4</b>	<b>-17.7%</b>
16	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	2.7%	1.4%	-1.3%	-46.8%
17	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	7,489,527.3	5,673,381.5	-1,816,145.8	-24.2%
18	<b>Нийт орлого</b>	<b>625,453.4</b>	<b>569,282.5</b>	<b>-56,170.9</b>	<b>-9.0%</b>
19	<b>Нийт зарлага</b>	<b>621,645.4</b>	<b>624,442.8</b>	<b>2,797.4</b>	<b>0.5%</b>
20	<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>3,808.0</b>	<b>-55,160.4</b>	<b>-58,968.4</b>	<b>-1,548.5%</b>

“Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үеэс 9.6 хувь буюу 10-аар буурсан байна. Тус ХЗХ-дын нийт хөрөнгө 9,675,522.5 мянган төгрөг нь салбарын 4.2 хувь, нийт зээл 7,926,441.3 мянган төгрөг нь салбарын 4.6 хувь, нийт хадгаламж 2,231,452.5 мянган төгрөг нь салбарын 1.4 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд тус ХЗХ-дын банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.2 хувиар буурснаар нийт орлого 9.0 хувиар, цэвэр орлого 1,548.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 3.1 Хөрөнгийн бүтэц

ХЗХ-дын тайлант хугацааны хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 9 /мянган төгрөгөөр/

№	ХӨРӨНГӨ	2019 оны I улирал	2020 оны I улирал	Өөрчлөлт
---	---------	-------------------	-------------------	----------




		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>206,932,757.1</b>	<b>97.8%</b>	<b>225,274,697.0</b>	<b>98.1%</b>	<b>18,341,939.9</b>	<b>8.9%</b>
1.1	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>45,220,894.5</b>	<b>21.4%</b>	<b>47,228,268.1</b>	<b>20.6%</b>	<b>2,007,373.6</b>	<b>4.4%</b>
	Бэлэн мөнгө	3,221,027.3	1.5%	2,630,809.2	1.1%	-590,218.1	-18.3%
	Банкинд байршуулсан харилцах	23,973,993.9	11.3%	36,906,556.9	16.1%	12,932,563.0	53.9%
	Банкинд байршуулсан хадгаламж	18,025,873.2	8.5%	7,690,902.0	3.4%	-	-57.3%
						10,334,971.2	
1.2	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>48,000.0</b>	<b>0.0%</b>	<b>100,000.0</b>	<b>0.0%</b>	<b>52,000.0</b>	<b>108.3%</b>
	Арилжааны үнэт цаас	48,000.0	0.0%	100,000.0	0.0%	52,000.0	108.3%
1.3	<b>ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/</b>	<b>152,782,897.8</b>	<b>72.2%</b>	<b>167,970,174.5</b>	<b>73.2%</b>	<b>15,187,276.7</b>	<b>9.9%</b>
	Нийт зээл	157,555,631.6	74.4%	172,940,234.8	75.3%	15,384,603.2	9.8%
	Хэвийн зээл	147,559,066.6	69.7%	159,524,180.4	69.5%	11,965,113.8	8.1%
	Хугацаа хэтэрсэн зээл	3,948,989.6	1.9%	6,005,784.5	2.6%	2,056,794.9	52.1%
	Чанаргүй зээл	6,047,575.4	2.9%	7,410,270.0	3.2%	1,362,694.6	22.5%
	Хэвийн бус зээл	1,267,891.4	0.6%	2,903,660.2	1.3%	1,635,768.8	129.0%
	Эргэлзээтэй зээл	1,125,044.3	0.5%	1,264,115.2	0.6%	139,070.9	12.4%
	Муу зээл	3,654,639.7	1.7%	3,242,494.6	1.4%	-412,145.1	-11.3%
	(Зээлийн эрсдэлийн сан )	4,772,733.7	2.3%	4,970,060.3	2.2%	197,326.6	4.1%
1.4	<b>АВЛАГА</b>	<b>7,312,112.9</b>	<b>3.5%</b>	<b>8,185,117.1</b>	<b>3.6%</b>	<b>873,004.2</b>	<b>11.9%</b>
	Байгууллага, хүмүүсээс авах авлага	944,925.2	0.4%	1,546,844.3	0.7%	601,919.1	63.7%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	6,367,187.7	3.0%	6,638,272.8	2.9%	271,085.1	4.3%
1.5	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>892,107.5</b>	<b>0.4%</b>	<b>1,048,850.0</b>	<b>0.5%</b>	<b>156,742.5</b>	<b>17.6%</b>
	Татварын авлага	12,839.3	0.0%	9,466.5	0.0%	-3,372.8	-26.3%
	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	416,760.4	0.2%	527,576.5	0.2%	110,816.1	26.6%
	Дараа тайлангийн тооцоо	213,634.4	0.1%	82,751.4	0.0%	-130,883.0	-61.3%
	Дутагдал, шамшигдал	21.4	0.0%	26.8	0.0%	5.4	25.3%
	Хангамжийн зүйлс	248,852.0	0.1%	428,935.4	0.2%	180,083.4	72.4%
	Салбар хоорондын авлага	0.0	0.0%	93.3	0.0%	93.3	
1.6	<b>ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВЭР/</b>	<b>676,744.5</b>	<b>0.3%</b>	<b>742,287.3</b>	<b>0.3%</b>	<b>65,542.8</b>	<b>9.7%</b>
	Өмчлөх бусад хөрөнгө	730,183.6	0.3%	792,698.0	0.3%	62,514.4	8.6%
	(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	53,439.1	0.0%	50,410.7	0.0%	-3,028.4	-5.7%
<b>2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		<b>4,737,277.2</b>	<b>2.2%</b>	<b>4,260,048.8</b>	<b>1.9%</b>	<b>-477,228.4</b>	<b>-10.1%</b>
2.1	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВЭР/</b>	<b>4,679,182.1</b>	<b>2.2%</b>	<b>3,994,784.4</b>	<b>1.7%</b>	<b>-684,397.7</b>	<b>-14.6%</b>
	Үндсэн хөрөнгө	5,789,908.5	2.7%	5,359,891.1	2.3%	-430,017.4	-7.4%
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,110,726.4	0.5%	1,365,106.7	0.6%	254,380.3	22.9%
2.2	<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>43,075.1</b>	<b>0.0%</b>	<b>249,644.4</b>	<b>0.1%</b>	<b>206,569.3</b>	<b>479.6%</b>
	Биет бус хөрөнгө	59,792.4	0.0%	303,644.5	0.1%	243,852.1	407.8%
	(Биет бус хөрөнгийн элэгдэл)	16,717.3	0.0%	54,000.1	0.0%	37,282.8	223.0%
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БУСАД ХӨРӨНГӨ	15,020.0	0.0%	15,620.0	0.0%	600.0	4.0%
2.3	Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.0	0.0%	15,620.0	0.0%	600.0	4.0%
<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>211,670,034.3</b>	<b>100%</b>	<b>229,534,745.9</b>	<b>100%</b>	<b>17,864,711.6</b>	<b>8.4%</b>

Салбарын нийт хөрөнгийн 98.1 хувь эргэлтийн хөрөнгө, 1.9 хувь эргэлтийн бус хөрөнгө байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгөд 20.6 хувийг, цэвэр зээл 73.2 хувийг тус тус эзэлж байна. Харин хэвийн бус зээл өмнөх оны мөн үеэс 129.0 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь зээлийн чанар муудаж байгааг харуулж байна.

ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал:

График 6



2016-2019 онуудад ХЗХ-дын тоо харьцангуй тогтвортой байсан бол хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн байна.

### 3.2 Хөрөнгийн төвлөрлийг интервалаар харуулбал:

Хүснэгт 10 /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүдийн тоо	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	3	142,248,389.15	62.0%	25,985	34.8%
2	1,000,000.0 -10,000,000.0	20	53,806,909.40	23.4%	18,326	24.5%
3	500,000.0-1,000,000.0	9	6,099,844.54	2.7%	2,968	4.0%
4	100,000.0-500,000.0	100	20,259,447.95	8.8%	17,527	23.5%
5	50,000.0-100,000.0	82	6,157,003.00	2.7%	7,860	10.5%
6	10,000.0-50,000.0	30	911,650.32	0.4%	1,755	2.3%
7	10,000.0 хүртэл	10	51,501.50	0.0%	280.00	0.4%
	Нийт дүн	254	229,534,745.9	100%	74,701	100%

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 3 ХЗХ-ны нийт хөрөнгө 142,248,389.2 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 62.0 хувийг, гишүүдийн тоо 25,985 байгаа нь нийт гишүүдийн 34.8 хувийг тус тус эзэлж байна.

### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд салбарын нийт зээл 172,940,234.8 мянган төгрөг нь нийт хөрөнгийн 75.3 хувийг, цэвэр зээл 167,970,174.5 мянган төгрөг нь хөрөнгийн 73.2 хувийг тус тус эзэлж байна. Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 3.1 хувь байна.

ХЗХ-дын зээлийн хэмжээг интервалаар харуулбал:


Хүснэгт 12 /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Нийт зээлд эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	17	141,465,871.2	81.8%
2	500,000.0-1,000,000.0	12	8,372,298.4	4.8%
3	100,000.0-500,000.0	73	15,133,073.2	8.8%
4	50,000.0-100,000.0	85	6,277,296.9	3.6%
5	10,000.0-50,000.0	49	1,657,710.3	1.0%
6	10,000.0 хүртэл	9	33,984.7	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	9	-	-
	Нийт дүн	254	172,940,234.8	100%

Салбарын нийт зээлийн 81.8 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн дүнтэй 17 ХЗХ-ны нийт зээл эзэлж байгаа бол зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй 9 ХЗХ байна.

Зээлийн дүн өндөртэй ХЗХ-дын хөрөнгөд эзлэх зээлийн хувь хэмжээ 56.8%-90.7%-тай байна.


Зээлийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 пунктээр буурч 92.2 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.0 пунктээр өсөж 3.5 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.5 пунктээр буурч 4.3 хувьд хүрсэн байна.

Зээлийн багцын өөрчлөлтийг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал:

График 9 /тэрбум төгрөгөөр/



## ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 4.1 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар

Тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 14 /мянган төгрөгөөр/


№	ЭХ ҮҮСВЭР	2019 I улирал		2020 I улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
	<b>1. ӨР ТӨЛБӨР</b>	<b>179,421,784.8</b>	<b>84.8%</b>	<b>186,313,141.0</b>	<b>81.2%</b>	<b>6,891,356.2</b>	<b>3.8%</b>

<b>1.1</b>	<b>ХАДГАЛАМЖ</b>	<b>150,978,793.2</b>	<b>71.3%</b>	<b>159,015,824.5</b>	<b>69.3%</b>	<b>8,037,031.4</b>	<b>5.3%</b>
	Хугацаагүй	2,885,413.8	1.4%	3,914,870.5	1.7%	1,029,456.7	35.7%
	Хугацаатай	148,093,379.4	70.0%	155,100,954.0	67.6%	7,007,574.6	4.7%
<b>1.2</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ</b>	<b>7,775,408.3</b>	<b>3.7%</b>	<b>3,296,601.6</b>	<b>1.4%</b>	<b>-4,478,806.7</b>	<b>-57.6%</b>
	Банкнаас авсан зээл	4,701,644.5	2.2%	867,750.5	0.4%	-3,833,894.0	-81.5%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	526,858.9	0.2%	563,054.9	0.2%	36,195.9	6.9%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	2,546,904.8	1.2%	1,791,579.5	0.8%	-755,325.3	-29.7%
	Тогтворжилтын сангийн туслалцаа	0.0	0.0%	74,216.7	0.0%	74,216.7	-
<b>1.3</b>	<b>БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>13,500,687.1</b>	<b>6.4%</b>	<b>16,524,405.3</b>	<b>7.2%</b>	<b>3,023,718.2</b>	<b>22.4%</b>
	Цалингийн өглөг	69,631.5	0.0%	91,458.7	0.0%	21,827.3	31.3%
	Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	723,050.1	0.3%	979,410.1	0.4%	256,360.0	35.5%
	Ногдол ашгийн өглөг	1,125,449.0	0.5%	861,914.2	0.4%	-263,534.8	-23.4%
	Санхүүгийн түрээсийн өглөг	652.5	0.0%	675.0	0.0%	22.5	3.4%
	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	0.0	0.0%	100.9	0.0%	100.9	-
	Урьдчилж орсон орлого	95,623.5	0.0%	148,901.9	0.1%	53,278.5	55.7%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	10,218,848.6	4.8%	12,996,513.7	5.7%	2,777,665.1	27.2%
	Салбар хоорондын тооцоогоорх өглөг	527,592.2	0.2%	0.0	0.0%	-527,592.2	-100%
	Бусад богино хугацаат өглөг	739,839.8	0.3%	1,445,430.8	0.6%	705,591.0	95.4%
<b>1.4</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,166,896.2</b>	<b>3.4%</b>	<b>7,476,309.5</b>	<b>3.3%</b>	<b>309,413.3</b>	<b>4.3%</b>
	Банкнаас авсан зээл	49,098.0	0.0%	106,218.6	0.0%	57,120.6	116.3%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	200,871.2	0.1%	2,379,921.0	1.0%	2,179,049.8	1,084.8%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	6,787,082.2	3.2%	4,972,173.3	2.2%	-1,814,908.9	-26.7%
	Тогтворжилтын сангийн туслалцаа	82,455.4	0.0%	0.0	0.0%	-82,455.4	-100%
	Хойшлогдсон татварын өр төлбөр	47,389.5	0.0%	17,996.6	0.0%	-29,392.9	-62.0%
<b>2.</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>32,248,249.6</b>	<b>15.2%</b>	<b>43,221,604.9</b>	<b>18.8%</b>	<b>10,973,355.3</b>	<b>34.0%</b>
<b>2.1</b>	<b>ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ</b>	<b>15,875,784.0</b>	<b>7.5%</b>	<b>18,414,215.3</b>	<b>8.0%</b>	<b>2,538,431.3</b>	<b>16.0%</b>
	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	15,688,929.4	7.4%	18,164,335.3	7.9%	2,475,405.9	15.8%
	Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	186,854.6	0.1%	249,880.0	0.1%	63,025.4	33.7%
<b>2.2</b>	<b>ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ</b>	<b>180,739.6</b>	<b>0.1%</b>	<b>160,800.8</b>	<b>0.1%</b>	<b>-19,938.9</b>	<b>-11.0%</b>
	Дахин үнэлгээний нэмэгдэл	180,739.6	0.1%	160,800.8	0.1%	-19,938.9	-11.0%
<b>2.3</b>	<b>ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ</b>	<b>16,191,725.9</b>	<b>7.6%</b>	<b>24,646,588.8</b>	<b>10.7%</b>	<b>8,454,862.9</b>	<b>52.2%</b>
	Нөөцийн сан	4,025,963.7	1.9%	5,118,403.3	2.2%	1,092,439.6	27.1%
	Хандив, тусламж	699,191.8	0.3%	525,590.0	0.2%	-173,601.8	-24.8%
	Хадгаламж, хамгаалалтын сан	1,273,678.1	0.6%	1,674,810.3	0.7%	401,132.3	31.5%
	Нийгмийн хөгжлийн сан	726,616.3	0.3%	1,151,033.9	0.5%	424,417.6	58.4%
	Тогтворжилтын сан	1,267,466.8	0.6%	1,678,101.4	0.7%	410,634.6	32.4%
	Бусад сангууд	1,068,058.9	0.5%	1,447,113.6	0.6%	379,054.8	35.5%
	Хуримтлагдсан орлого /алдагдал/	7,130,750.3	3.4%	13,051,536.3	5.7%	5,920,786.0	83.0%
	Тайлангийн үеийн цэвэр орлого	453,694.4	0.2%	2,194,705.1	1.0%	1,741,010.8	383.7%
	Өмнөх үеийн цэвэр орлого	6,677,055.9	3.2%	10,856,831.1	4.7%	4,179,775.2	62.6%
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>211,670,034.3</b>	<b>100%</b>	<b>229,534,745.9</b>	<b>100%</b>	<b>17,864,711.5</b>	<b>8.4%</b>

Салбарын нийт эх үүсвэрийн бүтцэд өр төлбөрийн хэмжээ 81.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ 18.8 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өсөхөд тайлангийн үеийн цэвэр орлогын өсөлт нөлөөлсөн байна.

Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлтийг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал:

График 10 /тэрбум төгрөгөөр/



ХЗХ-дын хоршоологчдын өмчийн хэмжээ 2016 оны 1 дүгээр улиралд 9.4 тэрбум төгрөг байсан бол 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 162.8 хувь буюу 15.3 тэрбум төгрөгөөр өсөж 24.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

#### 4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

Салбарын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 159,015,824.5 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 69.3 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн 97.5 хувь хугацаатай хадгаламж, 2.5 хувийг хугацаагүй хадгаламж тус тус эзэлж байна. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1.5 хувь байна.

ХЗХ-дын хадгаламжийг интервалаар харуулбал:


Хүснэгт 15 /мянган төгрөгөөр/

№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	3	107,474,538.9	67.6%
2	1,000,000.0-10,000,000.0	11	30,222,448.5	19.0%
3	500,000.0-1,000,000.0	9	6,832,982.8	4.3%
4	100,000.0-500,000.0	51	10,418,566.8	6.6%
5	50,000.0-100,000.0	23	1,636,694.4	1.0%
6	10,000.0-50,000.0	96	2,208,033.9	1.4%
7	5,000.0-10,000.0	22	161,091.8	0.1%
8	5,000.0 хүртэл	24	61,467.5	0.0%
9	Хадгаламжгүй	15	0.0	0.0%
	Нийт дүн	254	159,015,824.5	100%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүнгээр 10 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжтай 3 ХЗХ-ны хадгаламж нийт ХЗХ-дын хадгаламжийн дүнгийн 67.6 хувийг эзэлж байна. Хадгаламж татан төвлөрүүлээгүй 15 ХЗХ байна.

Салбарын хэмжээнд нийт хадгаламжийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал:

График 11 /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар 24.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### 4.3 Бусдаас авсан зээл

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтцийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 17 /мянган төгрөгөөр/

№	Бусдаас авсан зээл	Нийт	Нийт дүнд эзлэх хувь	УБ	Орон нутаг
				Дүн	Дүн
1	Банкнаас авсан зээл	973,969.2	9.1%	928,218.7	45,750.5
2	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	2,942,975.8	27.6%	2,892,921.0	50,054.9
3	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	6,763,752.9	63.3%	6,728,401.5	35,351.4
Нийт		10,680,697.9	100.0%	10,549,541.1	131,156.8

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 9.1 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 27.6 хувь, төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 63.3 хувийг тус тус эзэлж байна.

#### 4.4 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 18,414,215.3 мянган төгрөг нь нийт эх үүсвэрийн 8.0 хувийг эзэлж байна.

Салбарын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээг интервалаар харуулбал:

Хүснэгт 18 /мянган төгрөгөөр/

№	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн	
				Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	24,872	4,397,190.4	23.9%
2	500,000.0-1,000,000.0	6	3,629	3,503,542.2	19.0%
3	100,000.0-500,000.0	28	18,713	6,070,395.7	33.0%
4	50,000.0-100,000.0	18	4,486	1,271,255.2	6.9%
5	10,000.0-50,000.0	104	16,060	2,567,776.0	13.9%
6	5,000.0-10,000.0	67	5,285	500,529.8	2.7%
7	5,000.0 хүртэл	29	1,656	103,526.1	0.6%
Хувь хөрөнгийн дүн		254	74,701	18,414,215.3	100%

ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээг өмнөх онуудтай харьцуулбал:



#### 4.5 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

Тайлант улиралд ХЗХ-дын өөрийн хөрөнгө 43,221,604.9 мянган төгрөг нь нийт эх үүсвэрийн 18.8 хувийг эзэлж байна.

ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээг интервалаар харуулбал:

Хүснэгт 20 /мянган төгрөгөөр/

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	4	22,322,734.7	51.6%
2	500,000.0-1,000,000.0	12	8,230,530.5	19.0%
3	100,000.0-500,000.0	35	7,336,055.8	17.0%
4	50,000.0-100,000.0	38	2,574,863.6	6.0%
5	10,000.0-50,000.0	98	2,548,958.0	5.9%
6	10,000.0 доош	50	279,379.7	0.6%
7	Өөрийн хөрөнгөгүй	17	-70,917.4	-0.2%
Нийт өөрийн хөрөнгийн дүн		254	43,221,604.9	100%

ХЗХ-дын хоршоологчдын өмчийн дүнг интервалаар харуулбал:

Хүснэгт 22 /мянган төгрөгөөр/

№	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	15,463,973.6	62.7%
2	500,000.0-1,000,000.0	3	1,991,308.9	8.1%
3	100,000.0-500,000.0	19	4,416,389.7	17.9%
4	50,000.0-100,000.0	16	1,134,938.9	4.6%
5	10,000.0-50,000.0	75	1,699,212.4	6.9%
6	5,000.0-10,000.0	34	240,949.1	1.0%
7	1,000.0-5,000.0	35	92,416.8	0.4%
8	1,000.0 хүртэл	15	6,715.6	0.0%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	55	-399,316.1	-1.6%
Нийт дүн		254	24,646,588.8	100%

Алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон 55 ХЗХ байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.7 хувь буюу 8-аар буурсан үзүүлэлт юм.

### ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

#### 5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал:

## Хүснэгт 23 /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2019.I		2020.I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1. ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>12,112,326.9</b>	<b>96.0%</b>	<b>13,448,400.5</b>	<b>95.8%</b>	<b>1,336,073.6</b>	<b>11.0%</b>
Зээлийн хүүгийн орлого	11,494,742.7	91.1%	13,100,543.9	93.4%	1,605,801.2	14.0%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	61,840.3	0.5%	70,220.5	0.5%	8,380.2	13.6%
Үнэт цаасны хүүгийн орлого	0.00	0.0%	0.0	0.0%	0.0	-
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	600,932.3	4.8%	325,750.8	2.3%	-275,181.5	-45.8%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	0	0.0%	8,525.4	0.1%	8,525.4	-
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	45,188.4	0.4%	56,640.2	0.4%	11,451.8	25.3%
<b>2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО</b>	<b>319,505.2</b>	<b>2.5%</b>	<b>283,718.3</b>	<b>2.0%</b>	<b>-35,786.9</b>	<b>-11.2%</b>
Элсэлтийн хураамж	18,722.1	0.1%	10,161.2	0.1%	-8,560.9	-45.7%
Гишүүний татвар	12,839.8	0.1%	12,446.1	0.1%	-393.7	-3.1%
Үйлчилгээний шимтгэл, хураамж	276,040.3	2.2%	251,042.7	1.8%	-24,997.6	-9.1%
Түрээсийн орлого	2,350.0	0.0%	2,929.4	0.0%	579.4	24.7%
Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	9,552.9	0.1%	7,138.9	0.1%	-2,413.9	-25.3%
<b>3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>190,888.9</b>	<b>1.5%</b>	<b>301,043.0</b>	<b>2.1%</b>	<b>110,154.1</b>	<b>57.7%</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	0	0.0%	0.0	0.0%	0.0	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	82,122.4	0.7%	56,047.5	0.4%	-26,074.9	-31.8%
Үнэт цаасны арилжааны орлого	0.00	0.0%	0.0	0.0%	0.0	-
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	0	0.0%	0.0	0.0%	0.0	-
Торгуулийн орлого	465,616.8	0.0%	473.7	0.0%	8.1	1.7%
Бусад орлого	108,300.8	0.9%	244,521.9	1.7%	136,221.1	125.8%
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>12,622,720.9</b>	<b>100.0%</b>	<b>14,033,161.8</b>	<b>100.0%</b>	<b>1,410,440.9</b>	<b>11.2%</b>

Салбарын нийт орлого өмнөх оны мөн үеэс 11.2 хувь буюу 1,410,440.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 14,033,161.8 мянган төгрөгт хүрсэн байна.

## 5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал:

## Хүснэгт 24 /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2019.I		2020.I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1. ХҮҮГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,222,256.0</b>	<b>57.2%</b>	<b>7,562,674.2</b>	<b>53.9%</b>	<b>340,418.2</b>	<b>4.7%</b>
Хадгаламжийн хүүгийн зардал	7,074,945.9	56.0%	7,372,552.9	52.5%	297,607.0	4.2%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	139,248.5	1.1%	178,173.1	1.3%	38,924.6	28.0%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	887.8	0.0%	567.0	0.0%	-320.8	-36.1%
Бусад хүүгийн зардал	20,930.1	0.2%	19,923.9	0.1%	-1,006.2	-4.8%
(Хүүгийн зардлын буцаалт)	13,756.3	0.1%	8,542.7	0.1%	-5,213.6	-37.9%
<b>2. БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,256,795.9</b>	<b>10.0%</b>	<b>731,543.9</b>	<b>5.2%</b>	<b>-525,252.0</b>	<b>-41.8%</b>
Зээлийн эрсдэлийн зардал	1,351,868.5	10.7%	763,385.1	5.4%	-588,483.4	-43.5%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	-
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	95,072.6	0.8%	31,841.2	0.2%	-63,231.4	-66.5%
<b>3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>3,391,980.0</b>	<b>26.9%</b>	<b>3,279,462.5</b>	<b>23.4%</b>	<b>-112,517.5</b>	<b>-3.3%</b>




Боловсон хүчний зардал	2,146,121.5	17.0%	2,155,803.6	15.4%	9,682.1	0.5%
Бусад төрлийн зардал	1,245,858.5	9.9%	4,403,121.4	31.4%	3,157,262.9	253.4%
<b>4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>194,019.7</b>	<b>1.5%</b>	<b>32,071.2</b>	<b>0.2%</b>	<b>-161,948.5</b>	<b>-83.5%</b>
Торгуулийн зардал	465.7	0.0%	170.1	0.0%	-295.6	-63.5%
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	3,679.0	0.0%	0.0	0.0%	-3,679.0	-100.0%
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	110,582.3	0.9%	0.0	0.0%	-110,582.3	-100.0%
Өмчлөх бусад хөрөнгийг данснаас хассаны гарз	0.0	0.0%	3,000.0	0.0%	3,000.0	-
Өмчлөх бусад хөрөнгийг данснаас хассаны гарз	0.0	0.0%	8,850.0	0.1%	8,850.0	-
Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	-
Үйл ажиллагааны бус бусад зардал	194,019.7	1.5%	20,051.1	0.1%	-173,968.6	-89.7%
Татварын зардал	103,975.0	0.8%	232,704.8	1.7%	128,729.8	123.8%
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>12,169,026.6</b>	<b>100.0%</b>	<b>11,838,456.6</b>	<b>100.00%</b>	<b>-330,570.0</b>	<b>-2.7%</b>
<b>ЦЭВЭР ОРЛОГО</b>	<b>453,694.4</b>	<b>100.0%</b>	<b>2,194,705.1</b>	<b>100.00%</b>	<b>1,741,010.7</b>	<b>383.7%</b>

Салбарын нийт зардлын хэмжээ 11,838,456.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувь буюу 330,570.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 53.9 хувийг, үйл ажиллагааны зардал 23.4 хувийг тус тус эзэлж байна.

### 5.3 Ашигт ажиллагаа

Ашигт ажиллагааг өмнөх онуудтай харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

График 13 /тэрбум төгрөгөөр/



Салбарын цэвэр орлого 2016-2018 онуудын мөн үед 0.5 тэрбум төгрөг байсан бол 2019 оны мөн үед 0.1 тэрбум төгрөгөөр буурч 0.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 383.7 хувь буюу 1.8 тэрбум төгрөгөөр өсөж 2.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

### 5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

Тайлант улиралд 187 ХЗХ ашигтай, 12 ХЗХ ашиг, алдагдалгүй, 62 ХЗХ алдагдалтай ажиллаж салбарын хэмжээнд нийт 9,167,977.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ашигтай ажилласан ХЗХ-дыг ашгийн хэмжээгээр нь интервалаар харуулбал:

Хүснэгт 25 /мянган төгрөгөөр/

Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн өгөөж
100,000.0 дээш	3	1,979,408.6	70.7%	131,425,830.6	1.5%
50,000.0-100,000.0	1	78,381.0	2.8%	3,894,513.0	2.0%
10,000.0-50,000.0	17	428,242.5	15.3%	27,999,429.0	1.5%
5,000.0-10,000.0	21	162,069.9	5.8%	8,231,702.3	2.0%
1,000.0-5,000.0	52	124,497.9	4.4%	13,926,896.2	0.9%
1,000.0 хүртэл	61	25,472.0	0.9%	7,292,985.0	0.3%
Ашиг, алдагдалгүй	11	0.0	0.0%	1.0	0.0%
Нийт дүн	166	2,798,071.9	100%	192,771,357.1	1.5%

Нийт 254 ХЗХ-ноос 65.3 хувь буюу 166 ХЗХ нь 2,798,071.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. 100 сая төгрөгөөс дээш ашигтай ажилласан 3 ХЗХ-ны ашгийн салбарын нийт ашигт эзлэх хэмжээ 70.7 хувь байгаа бол хөрөнгийн өгөөж нь дунджаар 1.5 хувьтай байна.

### 5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

Нийт 254 ХЗХ-ны 34.6 хувь буюу 88 ХЗХ нь 603,366.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үеэс 18.9 хувь буюу 14-өөр өссөн үзүүлэлттэй байна.

Алдагдалтай ажилласан ХЗХ-дыг алдагдлын хэмжээгээр нь интервалаар харуулбал:

Хүснэгт 27 /мянган төгрөгөөр/

№	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	10,000.0 дээш	6	-442,826.6	73.4%
2	5,000.0-10,000.0 хүртэл	6	-46,816.2	7.8%
3	1,000.0-5,000.0 хүртэл	41	-99,327.8	16.5%
4	1,000.0 хүртэл	35	-14,396.2	2.4%
	Нийт дүн	88	-603,366.8	100%

Тайлант улиралд 10 сая төгрөгөөс дээш хэмжээний алдагдалтай ажилласан 6 ХЗХ-ны алдагдлын хэмжээ нийт алдагдлын 73.4 хувийг эзэлж байна.

## ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2020 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ээр тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Нийт 254 ХЗХ-ны шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

Хүснэгт 29

№	ҮЗҮҮЛЭЛТ	ЗХШҮ /ДМУ	БАЙВАЛ ЗОХИХ	Үзүүлэлт хангаагүй ХЗХ-дын тоо	Үзүүлэлт хангаагүй ХЗХ-дын хувь
<b>A</b>	<b>ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/		-24,356.9	16 ХЗХ дутуу байгуулсан	6.3%

2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	ЗХШҮ	5%-аас хэтрэхгүй	34	13.4%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	ЗХШҮ	30%-аас хэтрэхгүй	47	18.5%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	ЗХШҮ	30%-аас хэтрэхгүй	1	0.4%
<b>Б</b>	<b>ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	ЗХШҮ	60%-85%	101	39.8%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	ЗХШҮ	10%-аас хэтрэхгүй	10	3.9%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	ЗХШҮ	20%-80%	73	28.7%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	ЗХШҮ	20%-аас хэтрэхгүй	85	33.5%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	ЗХШҮ	10%-аас хэтрэхгүй	5	2.0%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	ЗХШҮ	5%-аас доошгүй	100	39.4%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	ЗХШҮ	-	20	7.9%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	ЗХШҮ	-	22	8.7%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	ЗХШҮ	-	23	9.1%
<b>В</b>	<b>ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ</b>				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	ЗХШҮ	15%-аас хэтрэхгүй	6	2.4%
<b>Г</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР</b>				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	ЗХШҮ	5%-аас доошгүй	93	36.6%
<b>Д</b>	<b>ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ</b>				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж				1.1%

Нийт 254 ХЗХ-ноос 16 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 24,356.9 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байгаа бол нийт ХЗХ-дын 13.4 хувь буюу 34 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцааг, 39.8 хувь буюу 101 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 28.7 хувь буюу 73 ХЗХ хадгаламжийн зохистой харьцааг, 33.5 хувь буюу 85 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцааг, 39.4 хувь буюу 100 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 36.6 хувь буюу 93 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. ХЗХ-ны салбарын хөрөнгийн өгөөж 1.1 хувь байна.

### **Нийт 254 ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:**

Хангаж ажиллаагүй тохиолдолд Хорооноос тухайн ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлэх хөрөнгө, эх үүсвэрийн 6 зохистой харьцааг ХЗХ-д хэрхэн хангаж ажилласныг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 33

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ	ХЗХ-дын тоо	ХЗХ-дын тоонд эзлэх хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	66	26.0%
2	1 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	74	29.1%
3	2 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	41	16.1%

4	3 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	45	17.7%
5	4 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	25	9.8%
6	5 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	3	1.2%
	Нийт дүн	254	100%

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар гол 6 ЗХШҮ-ийг ХЗХ-дын 26.0 хувь буюу 66 ХЗХ бүрэн хангаж ажилласан байна.

## ДОЛОО. ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 254 ХЗХ-ноос 26 ХЗХ өмнөх улирлын тайлангаар, 4 ХЗХ эхлэлтийн тайлангаар хамрагдсан болно.

### ХЗХ-дын статистик үзүүлэлт

Тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын эрхэлж буй санхүүгийн бусад ажил үйлчилгээг авч үзвэл тайлант хугацаанд ХЗХ-дын 40.2 хувь буюу 102 ХЗХ төслийн санхүүжилтийг дамжуулан хэрэгжүүлэх, 1.2 хувь буюу 3 ХЗХ санхүүгийн түрээсийн үйлчилгээ, 1.6 хувь буюу 4 ХЗХ даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна. Төслийн санхүүжилтийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй 102 ХЗХ-ны 92.2 хувь буюу 94 ХЗХ “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-д байна. Нийт 7 ХЗХ 61 салбарын зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 8,405-аар буюу 12.7 хувиар өсөж 74,701-д хүрсэн бол Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн тоо 49,450 буюу нийт гишүүдийн 66.2 хувь, орон нутгийн ХЗХ-дын гишүүдийн тоо 25,251 буюу нийт гишүүдийн 33.8 хувь, “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн ХЗХ-дын гишүүдийн тоо 9,093 буюу 12.2 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд ХЗХ-доос ирүүлсэн мэдээгээр нийт ХЗХ-дын 32.7 хувь буюу 83 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6.4 хувь буюу 5-аар нэмэгдсэн үзүүлэлт юм.

### Салбарын санхүүгийн үзүүлэлт

Санхүүгийн тайлангийн нэгтгэлээр ХЗХ-ны салбарын нийт хөрөнгө 229,534,745.9 мянган төгрөг нь банкны салбарын 0.7 хувь, нийт зээл 172,940,234.8 мянган төгрөг нь банкны салбарын 1.0 хувь, чанаргүй зээл 7,410,270.0 мянган төгрөг нь банкны салбарын 0.4 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 159,015,824.5 мянган төгрөг нь банкны салбарын 1.2 хувийг тус тус эзэлж байна. ХЗХ-дын нийт хувь хөрөнгө 18,414,215.3 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 8.0 хувь, хоршоологчдын өмч 24,646,588.8 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 10.7 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд 14,033,161.8 мянган төгрөгийн орлого олж, 11,838,456.6 мянган төгрөгийн зардал гарч, 2,194,705.1 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна. Цэвэр орлогын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 383.7 хувь буюу 1,741,010.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

“Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын нийт хөрөнгө 9,675,522.5 мянган төгрөг нь салбарын 4.2 хувь, нийт зээл 7,926,441.3 мянган төгрөг нь салбарын 4.6 хувь, чанаргүй зээл 234,964.0 мянган төгрөг

нь салбарын 3.2 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 2,231,452.5 мянган төгрөг нь салбарын 1.4 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд тус ХЗХ-д 569,282.5 мянган төгрөгийн орлого олж, 624,442.8 мянган төгрөгийн зардал гаргаж, 55,160.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### Хөрөнгийн бүтэц, зээлийн үйл ажиллагаа

Салбарын нийт хөрөнгийн бүтцийн 73.2 хувийг цэвэр зээл эзэлж байна.

ХЗХ-дын нийт хөрөнгөд эзлэх хэвийн зээл 69.5 хувь, хугацаа хэтэрсэн зээл 2.6 хувь, чанаргүй зээлийн хэмжээ 3.2 хувь байна. ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн нийт хөрөнгөд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Нийт чанаргүй зээлийн 92.1 хувийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын чанаргүй зээл эзэлж байна. “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын чанаргүй зээлийн салбарын нийт чанаргүй зээлд эзлэх хувь 3.2 хувь байна.

#### Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

ХЗХ-дын нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгийн 69.3 хувийг хадгаламж, 11.9 хувийг урт, богино хугацаат өр төлбөр, 8.0 хувийг гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, 10.7 хувийг хоршоологчдын өмч тус тус эзэлж байна. ХЗХ-ны гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн 97.5 хувийг хугацаатай хадгаламж, 2.5 хувийг хугацаагүй хадгаламж эзэлж байна.

#### Орлого, зарлага

Тайлант хугацаанд ХЗХ-ны салбарын нийт орлогын 95.8 хувийг хүүгийн орлого, 2.0 хувийг үйл ажиллагааны бусад орлого, 2.1 хувийг үйл ажиллагааны бус орлого, нийт зардлын 53.9 хувийг хүүгийн зардал, 23.4 хувийг үйл ажиллагааны зардал тус тус эзэлж байна. Салбарын хэмжээнд ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 383.7 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа боловч ХЗХ-дын 34.6 хувь буюу 88 ХЗХ 603,366.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ХЗХ-дын 26.0 хувь буюу 66 ХЗХ бүрэн хангаж ажилласан бөгөөд 39.8 хувь буюу 101 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 28.7 хувь буюу 73 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 36.6 хувь буюу 93 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг, 39.4 хувь буюу 100 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. Салбарын хөрөнгийн өгөөж 1.1 хувьтай байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР